




2019 оны 9 дүгээр сарын 13-20

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **949** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 108(11.4%) галзуугийн эрсдэлд өртсөн, 812(85.7%) хачигт халдвар, 6(0.6%) боом, 7(0.7%) тарваган тахал, 2(0.2%) хумхаа, 1(0.1%) ям, 4(0.4%) денги, 5(0.5%) бэтэг, 3(0.3) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:


Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 109 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5%-иар, эпидемиологийн 37 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (39.8%), чононд (17.6%), эзэнгүй нохойд (14.8%), үнэгэнд (9.3%), үхэрт (7.4%), мануулд (2.8%), мууранд (1.9%), тэмээнд (0.9%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 820 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.9%-иар, эпидемиологийн 37 дугаар долоо хоногтой харьцуулахад 35 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ХР-ын 654 сэжигтэй тохиолдлын 118 (18%), ХБ-ын 71 сэжигтэй тохиолдлын 13 (18.3%), ХЭ-ын 87 сэжигтэй тохиолдлын 16 (18.4%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн байдлаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 63 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна. **Энэ долоо хоногт** нийслэлийн ЧД-ийн 19-р хорооноос ирүүлсэн мэрэгч амьтны (1 ширхэг тарвага), Замын үүдийн (1 ширхэг огтон) дуудлаганд үйлчилсэн. лабораторийн шинжилгээ хийхэд тарваган тахлын үүсгэгч илрээгүй байна.

ЗӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж